



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/117

Баян-Овоо

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
танхимын дуудлага худалдааг дахин зохион байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний танхимын дуудлага худалдааг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 09.00-15.00 цагийн хооронд зохион байгуулсугай.

2. Газруудын зориулалт, хэмжээ, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, эзэмшүүлэх хугацаа, дуудлага худалдаа эхлэх цагийн хуваарийг доорхи дурьдсанаар тогтоосугай.


- Баян-Овоо /4-р/ баг, Хасар гудамж, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор зориулалттай 371 м² газрын анхны үнэ 296800 (Хоёр зуун ерэн зургаан мянга найман зуун) төгрөг, дэнчингийн хэмжээ 29680 (Хорин есөн мянга зургаан зуун наян) төгрөг, эзэмшүүлэх хугацаа 30 жил, дуудлага худалдаа 09 цаг 00 минутанд эхлэх:

3. Газрын танхимын дуудлага худалдааг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/117 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000335